



205

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН
САЙДЫН ТУШААЛ

2018 оны 08 сарын 30 едер

Дугаар A/544

Улаанбаатар хот

Г Тушаалд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.7 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2012 оны "Журам батлах тухай" 19 дүгээр тогтоолоор батлагдсан "Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээл олгох журам"-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны "Боловсролын зээлийн сангийн зээлийн санхүүжилтээр гадаадад суралцуулах тухай" 2018 оны А/368 дугаар тушаалын хавсралт дахь Бат-Өлзий овогтой Энхзулд холбогдох хэсгийн "University of Szeged" гэснийг "Central European University" гэж, Луузандамба овогтой Булганд холбогдох хэсгийн "Harvard University" гэснийг "Graduate Institute of International and Development Studies" and "Harvard University" гэж, Сэр-Од овогтой Долгорд холбогдох хэсгийн "Western Sydney University" гэснийг "Torrens University Australia" гэж, Гочоо овогтой Азжаргалд хобогдох хэсгийн "Australian national university" гэснийг "Macquarie University" гэж, 2016 оны А/09 дугаар тушаалын хавсралт дахь Хүрэлбаатар овогтой Азбилээт холбогдох хэсгийн "Birkbeck University of London" гэснийг "University of Sunderland" гэж, 2016 оны А/221 дугаар тушаалын хавсралт дахь Цэдэндамба овогтой Отгонбаярт холбогдох хэсгийн "Australian National University" гэснийг "MIP Politecnico di Milano Graduate School of Business" гэж, 2017 оны А/125 дугаар тушаалын хавсралт дахь Дорж овогтой Лхагвасурэнд холбогдох хэсгийн "Eotvos Lorand University" гэснийг "Corvinus University of Budapest" гэж тус тус өөрчилсүгэй.

2. Суралцагчтай зохих журмын дагуу гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /М.Ариунжаргал/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Гадаад хамтын ажиллагааны хэлтэс /Т.Ууганбаяр/-т тус тус даалгасугай.

САЙД

Ц.ЦОГЗОЛМАА

